

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 91 хувьд хүрсэн ч Төсвийн ерөнхийлөн захирагч нь арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН КОД: ХЭА-2026/05-22-ШТА-НА

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ

Хэрлэн сум 2026 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан

Утас: 88032817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Т.Алтаншагай

Утас: 92116768 Цахим хаяг: altanshagait@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



Аудитыг гүйцэтгэсэн:

Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар

Аудитын менежер
Д.Оюунтуяа

Ахлах аудитор:
Д.Эрдэнэбилэг
Ц.Билэгсайхан

Аудитор:
Т.Алтаншагай

Аудитын тайлан,
дүгнэлт, зөвлөмжтэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах, холбогдох
саналаа өгөхийг хүсвэл
70562112 дугаарын
утсаар харилцана уу.

Аудитын тайланг УАГ-
ын www.open.audit.mn
цахим хуудаснаас үзнэ
үү.

Хаяг: Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар

Хэрлэн сум, 4-р баг,
аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....7

БҮЛЭГ 1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 40.8% нь төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна..... 10

1.1. ОНХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 93.4 хувийг аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан боловч, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь баримтаар нотлогдохгүй байна..... 10

1.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 27 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна..... 12

БҮЛЭГ 2. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацааг зөрчин худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна..... 14

2.1. Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацааг мөрдөөгүй, төсвийн тодотголоор батлагдсан 6 төсөл, арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлээгүй байна..... 14

2.2. Худалдан авах ажиллагааны явцад гарсан гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.16

БҮЛЭГ 3. Гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний 91.0 хувь нь бүрэн хэрэгжиж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна..... 16

3.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн батлагдсан санхүүжилтийн 92.3 хувийг олгосон байна..... 16

3.2. Барилга байгууламжид захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн боловч фото зургаар баталгаажуулан тайлагнаагүй, архивын баримт үүсгээгүй байна..... 18

3.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг бүрэн бүртгэж, хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна..... 20

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: 22

ДҮГНЭЛТ: 23

ЗӨВЛӨМЖ: 24

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 04 дугаар сарын 09

Дугаар А/08

Чингис хот

Г Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, 2025 оны А/161 дугаар тушаалаар баталсан “Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 2025 оны А/175 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэхь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Хэрлэн сумын Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.
4. Аудитаар өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Аюурбунь/-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож, тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэгч аудиторын 2025 оны
04 дугаар сарын 09 ны өдрийн А/08 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

"Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" нийцлийн аудитаар
өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчил хариуцах		Зөрчлийн утга	Албан шаардлагын дугаар	Дүн /төгрөг/
	Байгууллага	албан тушаалтан			
1	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	дарга Б.Сүнгээ	"Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/, "Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/" төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан, фото зургаар баримтжуулаагүй	292-A2360446 ХЭА-2026/05-22-ШТА-НА	
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Аюурбунь	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, техникийн нөхцөлгүй 324.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг 4 сумын ИТХ-аар, 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалт /Жаргалтхаан/ нь зураг төсөв, техникийн нөхцөлгүй байхад аймгийн ИТХ-аар батлуулсан	296-A2371043 ХЭА-2026/05-22-ШТА-НА	977,623,000.0
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Аюурбунь	ОНХО-аар ажлын даалгаваргүй 235.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ, техникийн тодорхойлолтгүй 206.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-г төлөвлөсөн.	295-A2371043 ХЭА-2026/05-22-ШТА-НА	442,395,890.0
4	Худалдан авах ажиллагааны газарт	Дарга Т.Батдорж	1. "Сумын эрүүл мэндийн төвийн машин", "Сумдын Засаг даргын Тамгын газрын автомашин"-ы гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хорооны хуралд аймгийн ЗД-ын 2025 А/201 дүгээр захирамжаар томилоогүй иргэний төлөөлөл оролцсон. 2. Үнэлгээний хороо нь 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй "Сумын эрүүл мэндийн төвийн машин" төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй санал ирүүлсэн гүйцэтгэгчийг шалгаруулсан. 3. Техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангаагүй, зах зээлийн үнээс өндөр үнэтэй хөрөнгийг бэлтгэсэн.	291-A2361113 ХЭА-2026/05-22-ШТА-НА	100,000,000.0
5	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Аюурбунь	"Батширээт сумын ЗДТГ-ын байрны засвар" ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг Батширээт сумын Засаг даргад шилжүүлсэн боловч хяналтыг хэрэгжүүлээгүйгээс гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй.	294-A2360446 ХЭА-2026/05-22-ШТА-НА	
6	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Аюурбунь	Аймгийн Засаг даргын 2025 оны А/46 дугаар захирамжаар байгуулсан комисс нь "Мөнгөн шил-Шилэн хийц" ХХК-аас авто машиныг хүлээн авахдаа техникийн тодорхойлолтод нийцээгүй, гүйцэтгэгчийн санал болгосноос өөр 176.5 сая төгрөгийн "Toyota 4Runner" маркийн автомашиныг хүлээн авсан.	290-A2361113 ХЭА-2026/05-22-ШТА-НА	176,500,000.0
7	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Эрдэнэбаатар	Засгийн газрын 2021 оны 212 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг зөрчин Хэрлэн сумын Засаг дарга ашиглалтад оруулах комиссыг томилон барилга байгууламж, их засварын 3 төсөл, арга хэмжээг хүлээн авсан.	293-A2360446 ХЭА-2026/05-22-ШТА-НА	
ДҮН					1,696,519,490.0

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Дүрслэл 1</i>	<i>Хөрөнгө оруулалтын эх үүсвэр</i>	10
<i>Дүрслэл 2</i>	<i>Зураг төслийн ажлууд</i>	11
<i>Дүрслэл 3</i>	<i>Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа</i>	15
<i>Дүрслэл 4</i>	<i>Төсөл, арга хэмжээний санхүүжилт</i>	17
<i>Дүрслэл 5</i>	<i>Төсөл, арга хэмжээний хэрэгжилт</i>	20

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Зураг 1</i>	<i>Тендерт шалгарсан болон нийлүүлсэн автомашины харьцуулалт</i>	18

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Хүснэгт 1</i>	<i>Аймгийн 2026-2030 оны үндсэн чиглэлтэй нийцэхгүй төсөл, арга хэмжээ</i>	10
<i>Хүснэгт 2</i>	<i>Ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээ</i>	13
<i>Хүснэгт 3</i>	<i>Техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээ</i>	13

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалыг үндэслэн тус аудитыг хийж гүйцэтгэлээ.</p>
Аудитын зорилт	<p>“Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.</p> <p>Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх,• Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьсан эсэх,• Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх,
Аудитын хамарсан хүрээ	<p>Аудитад аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, ХАА газар, Цэнхэрмандал, Батширээт, Хэрлэн, Бор-Өндөр сумын ЗДТГ зэрэг төрийн байгууллагууд, хөрөнгө оруулалтыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ</p>
Аудитын арга зүй	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн баримт материал нягтлан шалгах зэрэг судалгааны арга зүйг ашигласан.</p>

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”;
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар тус тус баталсан баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;
- Аймгийн ИТХ-ын 2024 оны 3 дугаар хуралдааны 05, 2025 оны 7 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолууд,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Батлагдсан зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлэн ахлах аудитор Д.Эрдэнэбилэг, Ц.Билэгсайхан, аудитор Т.Алтаншагай нар 2026 оны 01 дүгээр сарын 21-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 13,968.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 9,884.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 76 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр аймгийн ИТХ болон Хэрлэн, Бор-Өндөр, Батширээт, Цэнхэрмандал сумын ИТХ баталсан байна.

Үүнээс он дамжин хэрэгжих 14 төсөл, арга хэмжээнд 1,600.8 сая төгрөг, шинээр хэрэгжүүлэх 62 төсөл, арга хэмжээнд 8,284.2 сая төгрөгийн санхүүжилтийг баталсан бөгөөд 540.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг Цэнхэрмандал, Жаргалтхаан, Батширээт сумын Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

Нийт хөрөнгө оруулалтын 76 төсөл, арга хэмжээний 27 нь их засварын, 13 нь барилга байгууламжийн, 21 нь тоног төхөөрөмжийн, 9 нь зураг төсвийн, 6 нь бусад төсөл, арга хэмжээ байна.

Дээрх ажлуудаас төрийн байгууллагуудад 26, дэд бүтцийн салбарын 9, боловсрол, соёлын салбарын 27, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарын 6, хөдөө аж ахуйн салбарын 2, бусад чиглэлийн 6 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Шинээр 2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 51 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулснаар 509.5 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.

Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй 13,113.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, тайлант онд гүйцэтгэлээр 9,885.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 12,411.2 сая төгрөгийн 53 төсөл, арга хэмжээг холбогдох сумын төрийн байгууллагуудад бүрэн бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан байна. Харин 111.1 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг холбогдох байгууллагын урьдчилж гарсан зардал дээр бүртгэсэн ба 2026 онд шийдвэр гарган холбогдох байгууллагын санхүүгийн тайланд тусгахаар төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 12,544.5 сая төгрөгийн 60 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаж, 568.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ онд дамжин хэрэгжиж байгаа бол, 308.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 40.8% нь төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

1.1. ОНХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 93.4 хувийг аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулсан боловч, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь баримтаар нотлогдохгүй байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 76 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс аймгийн 2026-2030 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн 71 төсөл, арга хэмжээ байна.

Харин Бор-Өндөр, Цэнхэрмандал сумдын ИХТ-аар урсгал зардлын шинжтэй 5 төсөл, арга хэмжээ нь аймгийн 2026-2030 оны үндсэн чиглэлтэй нийцэхгүй байна.

Дүрслэл 1. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр

№	Төсөл, арга хэмжээний нэр	Сум	Аймгийн 2026-2030 оны үндсэн чиглэлтэй нийцсэн эсэх
1	Тээвэр шатахуун худалдан авах	Бор-Өндөр	Үгүй
2	Бичиг хэрэг	Бор-Өндөр	Үгүй
3	Шуудан холбоо	Бор-Өндөр	Үгүй
4	Урсгал засвар	Бор-Өндөр	Үгүй
5	Ойн ангид дэмжлэг	Цэнхэрмандал	Үгүй

Хүснэгт 1. Аймгийн 2026-2030 оны үндсэн чиглэлтэй нийцэхгүй төсөл, арга хэмжээ

Дараа онуудад хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн Сумын хөгжлийн төлөвлөгөө /Батширээт/, Өлзийт, Тахилгат тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ЗДТГ-ын барилгын төсөв шинэчлэх /Батширээт/, Автозамын зураг /Батширээт/, Соёлын төвийн бельэтажны өргөтгөл хийх ажлын зураг төсвийг хийлгүүлэх зэрэг 5 төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар баталж орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Дараа онуудад хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн Сумын хөгжлийн төлөвлөгөө /Батширээт/, Өлзийт, Тахилгат тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ЗДТГ-ын барилгын төсөв шинэчлэх /Батширээт/, Автозамын зураг /Батширээт/, Соёлын төвийн бельэтажны өргөтгөл хийх ажлын зураг төсвийг

хийлгүүлэх зэрэг 5 төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар баталж орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-аас баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 37 төсөл, арга хэмжээг албан байгууллагаас ирүүлсэн хүсэлт, баримт бичигт үндэслэн аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлөөр ач холбогдол, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагатай төсөл, арга хэмжээг эсэхийг хэлэлцэж төлөвлөж байна.



Дүрслэл 2. Зураг төслийн ажлууд

Сумын ИТХ-аас баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 39 төсөл, арга хэмжээний талаар баримт байхгүйгээс эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, эрэмбэлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвөөс бүрдэнэ.",

22 дугаар зүйлийн

22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.

22.2.Төсвийг дор дурдсаны дагуу ангилна:

22.2.1.төсвийн шатлалаар;

22.2.2.төсвийн захирагчаар;

22.2.3.эдийн засгийн ангиллаар;

22.2.4.хөтөлбөрөөр;

22.2.5.арга хэмжээгээр;

22.2.6.санхүүжүүлэх эх үүсвэрээр.

22.6.5-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;" гэж заасан.

Аймгийн хэмжээнд 7 сум хөрөнгө оруулалтын шинж чанартай арга, хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Үүнээс сумын ЗДТГ-ын бусад хөрөнгийн зардал ангилалд төсвийг тусгасан арга хэмжээг сумын ИТХ-аар хөрөнгө оруулалтад батлаагүй, урсгал зардлын шинжтэй арга, хэмжээг төлөвлөсөн, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга, хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтаар батлуулсан нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журамд

заасан орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагад нийцэхгүй байна.

1. Баянмөнх, Биндэр, Өмнөдэлгэр сумд орон нутгийн хөрөнгө оруулалтын 142.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар батлуулахгүйгээр хэрэгжүүлсэн.
2. Бор-Өндөр, Цэнхэрмандал сумд урсгал зардлын шинжтэй 87.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөж сумын ИТХ-аар батлуулсан.
3. Бор-Өндөр сум Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс санхүүжих 18 төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад оруулж ИТХ-аар батлуулсан.

Шийдвэрлэлт: /Аймгийн Засаг даргад зөвлөмж/

Аудитад сумдын ИТХ-аар орон нутгийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, арга хэмжээг хамруулсан болно.

1.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 27 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”, 29¹.2.2-д “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;” заасан хөрөнгө оруулалтын төсөвлөлт, тавигдах шаардлагад нийцээгүй техникийн нөхцөлгүй, магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй 744.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламжийн дараах 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Үүнд:

Аймгийн ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалт:

- Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалт /Жаргалтхаан/,

Сумын ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалт:

- Дулааны шугам,
- Уурхайчин 4-р багт "Сагсан бөмбөг"-ийн хашаа барих,
- 5, 6-р багт хийгдэх гүний худаг,
- 5, 6-р багт хийгдэх гүний худаг,
- Язгууртан хорооллын тохижилт /К33 а,б/,
- Авто замын тэмдэг тэмдэглэгээ,
- Ойн ангийн байрны дотор, гадна тохижилт төсөл арга хэмжээнүүд байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн Засаг даргад албан шаардлага/

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4.5-д “холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар;” заасан техникийн тодорхойлолтгүй 310.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга

хэмжээ, ажлын даалгаваргүй 131.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээний өртгийг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн Засаг даргад албан шаардлага/

№	Төсөл, арга хэмжээ	Сум	Төсөвт өртөг
1	Батширээт сумын ЗДТГ-ын байрны засвар	Батширээт	20,000,000.0
2	ЗДТГ-ын барилгын төсөв шинэчлэх	Батширээт	500,000.0
3	Автозамын зураг	Батширээт	20,000,000.0
4	Соёлын төвийн бөмбөгөр өргөтгөл хийх ажлын зураг төсвийг хийлгүүлэх	Бор-Өндөр	8,000,000.0
5	Урсгал засвар	Бор-Өндөр	10,000,000.0
6	ЗДТГ-ын ажлын байрны хэсэгчилсэн засвар хийлгэх ажил	Бор-Өндөр	39,400,000.0
7	Газрыг хамгаалах нөхөн сэргээх	Бор-Өндөр	12,000,000.0
8	Замын тэмдэг, тэмдэглэгээ	Бор-Өндөр	2,500,000.0
9	Сумын төв доторх авто замын засвар	Бор-Өндөр	19,000,000.0
	ДҮН		131,400,000.0

Хүснэгт 2. Ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээ	Сум	Төсөвт өртөг
1	Газар ухагч машин	Батширээт	140,000,000.0
2	Зөөврийн байр /чиргүүл/	Батширээт	20,000,000.0
3	Иргэний бүртгэлд 4G сүлжээний төхөөрөмж, компьютер авах	Бор-Өндөр	6,000,000.0
4	2-р цэцэрлэг хүүхдийн ор	Бор-Өндөр	8,500,000.0
5	"Оюуны уурхай" сургуулийн шилэн ангийн зориулалтын хатаасан шил худалдан авах	Бор-Өндөр	14,370,100.0
6	"Оюуны уурхай" сургуулийн анги засварын ажлын дагалдах хэрэгсэл худалдан авах	Бор-Өндөр	6,925,790.0
7	Улсын бүртгэлийн зөөврийн 4G төхөөрөмж /улсын бүртгэл, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цогц үйлчилгээг хүргэх төхөөрөмж/	Цэнхэрмандал	700,000.0
8	Мэдээллийн орчин үеийн цахим дэлгэц шинээр байршуулах	Цэнхэрмандал	10,000,000.0
9	Орон нутаг сурталчлах танхим байгуулах, үзвэр /Цэнхэрмандал/	Цэнхэрмандал	100,000,000.0
10	Хүүхдийн 4-р цэцэрлэгийн гадна хаягжуулалт	Бор-Өндөр	4,500,000.0
	ДҮН		310,995,890.0

Хүснэгт 3. Техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээ

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 76 төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29.3.5-д “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан

хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.3.4.2-д “шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.” гэх заалтуудтай нийцүүлж төлөвлөсөн байна.

Шинээр 2025 онд эхлүүлэхээр төлөвлөсөн 5,705.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4,220.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 13 төсөл, арга хэмжээ нь 2026 он дамжин хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Шилжих 13 төсөл, арга хэмжээг аймгийн хөрөнгө оруулалтаар 2 жилд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үүнээс 5 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжиж эхэлсэн эхний жилд 100% олгохоор, үлдсэн 8 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 50%-71.6% эхний жилд олгохоор төлөвлөж хуваарилсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;” заасантай нийцэж байна.

БҮЛЭГ 2. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацааг зөрчин худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2.1. Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацааг мөрдөөгүй, төсвийн тодотголоор батлагдсан 6 төсөл, арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр эхлүүлэх 27 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн Засаг даргаар батлуулан shilendans.gov.mn цахим системд байршуулсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2025 оны төсвийн тодотгол хийснээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр нэмэлт өөрчлөлтийг батлуулсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, нэмэлт өөрчлөлтийг оруулахдаа Засгийн газрын 2023 оны 250 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.4, 2.11 дэх хэсэгт заасан хугацааг баримтлах, төсөвт тодотгол орсон бол төсөв батлагдсан даруйд хэрэгжүүлэхээр тусгахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс аймгийн Засаг даргын захирамжаар 540.0 сая төгрөгийн төсөвт өртөг,

санхүүжих дүн бүхий 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг холбогдох сумдын Засаг даргад шилжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 26 төсөл, арга хэмжээнээс 23 төсөл, арга хэмжээний зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн байх бөгөөд 3 төсөл, арга хэмжээ нь холбогдох сумдад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн ажлууд байна.

Тендерийн баримт бичигт оролцогчдод тавих шаардлагыг тусгасан эсэхийг үнэлэхэд төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ, онцлог, цар хүрээнд тулгуурлан ерөнхий шаардлага, санхүүгийн чадавхын шаардлага, техникийн чадавх болон туршлагын шаардлага, тусгай зөвшөөрлийн шаардлага зэргийг тендерийн баримт бичигт тусган боловсруулж худалдан авах ажиллагааг зарласан байна.

Аймаг, сумын ИТХ-аар орон нутгийн хөрөнгө оруулалтаар 76 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас тайлант онд шинээр хэрэгжих 60 төсөл, арга хэмжээ байна.

Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 12 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 18 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгийг сонгон шалгаруулсан байна. Үлдсэн 10 төсөл, арга хэмжээнээс 5 нь урсгал зардлын шинжтэй арга хэмжээг төлөвлөсөн бол 5 нь худалдан авах ажиллагаанд оролцогч ороогүй, батлагдсан төсөвт өртөг нь тухайн ажлыг гүйцэтгэхэд хүрэлцэхээр хэмжээнд төлөвлөөгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.



Дүрслэл 3. ХАА зохион байгуулалт

Тайлант онд худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээнээс 224.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 2 төсөл, арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг зөрчсөн, 268.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 6 төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын 2023 оны 250 дугаар тогтоолоор баталсан журмын 2.4 дэх хэсэгт зааснаар тодотгол батлагдсан даруйд хэрэгжүүлэхээр тусгах тухай зохицуулалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн Засаг даргад зөвлөмж/

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан 50 төсөл, арга хэмжээнээс 49 төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан ерөнхий шаардлага,

санхүүгийн чадавхын шаардлага, техникийн чадавх болон туршлагын шаардлага, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангасан оролцогчийг шалгаруулсан байна.

Харин аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй "Сумын эрүүл мэндийн төвийн машин" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороо нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй санал ирүүлсэн гүйцэтгэгчийг шалгаруулж зах зээлийн үнээс өндөр үнэтэй хөрөнгийг бэлтгэсэн байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн ХАА-ны газарт албан шаардлага/

2.2. Худалдан авах ажиллагааны явцад гарсан гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын "Эмнэлгийн тоног төхөөрөмж" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны шалгаруулалтын явцад 2 оролцогч Сангийн яаманд холбогдох гомдлыг гаргасан байна.

Сангийн яамнаас уг гомдлыг хянан үзээд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийх тухай шийдвэрийг хуулийн хугацаанд багтаан ирүүлсэн байна.

Сангийн яамнаас ирүүлсэн шийдвэрийн дагуу "Эмнэлгийн тоног төхөөрөмж" төсөл, арга хэмжээний тендер хянан үзэх, үнэлэх ажлыг дахин хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж бараа нийлүүлэх гэрээг байгуулсан байна.

БҮЛЭГ 3. Гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний 91.0 хувь нь бүрэн хэрэгжиж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

3.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн батлагдсан санхүүжилтийн 92.3 хувийг олгосон байна.

Аймаг, сумын ИТХ-аар баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын шилжих болон шинээр хэрэгжүүлэх 66 төсөл, арга хэмжээнд бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээг байгуулснаас тайлант хугацаанд 12,582.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 60 төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжсэн байна.

Хугацаандаа хэрэгжээгүй 580.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 6 ажлаас 3 ажлын гэрээг 2026 онд хүлээж авахаар гэрээг сунгасан байна.

Батширээт сумын ИТХ-аар 2026 оны төсөвт "Газрын нэршил тогтоох" ажлыг шилжих хөрөнгө оруулалтаар тусган баталсан бол Бор-Өндөр сумын "Газрыг хамгаалах нөхөн сэргээх" ажлыг 2026 оны төсөвт тусгаагүй байна.



Дүрслэл 4. Төсөл, арга хэмжээний санхүүжилт

Тайлант онд бүрэн болон дутуу хэрэгжсэн 66 төсөл, арга хэмжээнд нийт 9,885.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс ажлын гүйцэтгэлд 9,237.9 сая, захиалагчийн хяналтын зардалд 80.7 сая, зохиогчийн хяналтын зардалд 251.2 сая төгрөгийг олгож 242.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

Бор-Өндөр, Цэнхэрмандал сумын ИТХ-аар орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад урсгал зардлын шинжтэй 395.5 сая төгрөгийн 5 ажлыг /тээвэр шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо, урсгал засвар, түр ажилтны цалин/ төлөвлөн баталж 76.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс Батширээт сумын Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг нь шилжүүлсэн “Батширээт сумын ЗДТГ-ын байрны засвар”-ын ажлыг бүрэн гүйцэтгэж, комиссоор хүлээж аваагүй байхад 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн Засаг даргад албан шаардлага/

Бүрэн хэрэгжсэн 60 төсөл, арга хэмжээнээс 59 төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.

Батширээт, Бор-Өндөр сумын 404.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.29 дэх заалттай нийцэхгүй байна.

Тайлант хугацаанд бүрэн хэрэгжсэн 60 төсөл, арга хэмжээнээс 12,140.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 42 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажилласан байна.


Гэрээ дүгнэх ажлын хүрээнд гэрээнд заасан хугацаандаа хэрэгжүүлээгүй “Хэрлэн-4-р цэцэрлэгийн хэсэгчилсэн засварын ажил”-ын гүйцэтгэлээс 31.9 сая төгрөгийн алдангийг тооцож санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны А/46 дугаар захирамжаар байгуулсан комисс нь аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын 176.5 сая төгрөгийн “Сумдын ЗДТГ-ын автомашин” төсөл, арга хэмжээнд шалгарсан "Мөнгөн шил-Шилэн хийц" ХХК-аас авто машиныг хүлээн авахдаа техникийн тодорхойлолтод нийцээгүй, гүйцэтгэгчийн санал болгосноос өөр "Toyota 4Runner" маркийн автомашиныг хүлээн авсан байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн ЗДТГ-ын дарга албан шаардлага/

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Баруаны нэр: Toyota Land Cruiser-200

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барганы үзүүлэлт тус бүрийг дөр жагсааж бичих ба хүрэн чанарын баталгаат хувиар ишардаг бэл бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (Захиалагчийн техникийн тодорхойлолтыг хүлээхгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барганы техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	1.Сурдал: 5 хүний суудалтай 2.Үйлдвэрлэсэн улс: Япон 3.Үйлдвэрлэсэн он: 2015 оноос дэвши 4.Техникийн байдал: 2015 онд Мөнгөл Улсад импортлогдсон, хөдөлгүүр явах эд анги, тоормосны систем хэвийн ажиллагаатай 5.Марк: Toyota LAND CRUISER 200-дүгнээгүй 6.Жоосоны хүрний байрлал: Хаммааралгүй 7.Шатахууны төрөл: Бензин 8.Хөдөлгүүрийн багтаамж: 4000сс 9.Автомашины өнгө: Улаан хүрэнгээс бусад 10.Хүрний хайрцаг: Автомат 11.Хөтлөгч: Fulltime-тай ардаа хөтлөгчтэй, дөрвөн дугуй маасждаг. 12.Хаалганы тоо: 5	1.Сурдал: 5 хүний суудалтай 2.Үйлдвэрлэсэн улс: Япон 3.Үйлдвэрлэсэн он: 2015 оноос дэвши 4.Техникийн байдал: 2015 онд Мөнгөл Улсад импортлогдсон, хөдөлгүүр явах эд анги, тоормосны систем хэвийн ажиллагаатай 5.Марк: Toyota LAND CRUISER 200 6.Жоосоны хүрний байрлал: баруун 7.Шатахууны төрөл: Бензин 8.Хөдөлгүүрийн багтаамж: 4000сс 9.Автомашины өнгө: Цагаан 10.Хүрний хайрцаг: Автомат 11.Хөтлөгч: Fulltime-тай ардаа хөтлөгчтэй, дөрвөн дугуй маасждаг. 12.Хаалганы тоо: 5	

АВТОМАШИН ХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН АКТ
2025 оны 06 сарын 09-ний өдөр
Дугаар ОНТ-2025/06
Хэнтэй хөтэймэг

- НЭГ ӨРӨНХИЙ ЗҮЙЛ
1.1 Гэрээний нэр, дугаар, оноо: Сумдын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах ажлын гэрээ ХЭАХААГ/20250102002, 2025 оны 05 сарын 09-ний өдөр
1.2 Тонг төхөөрөмжийн нэр, хүчин чадал: Хэнтий аймгийн сумдын ЗДТГ-т автомашин
1.3 Захиалагч байгууллага: Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар
1.4 Гүйцэтгэгч байгууллага: "Мөнгөн шил-Шилэн хийц" ХХК
1.5 Хэнтий аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны 06 сарын 09-ний өдрийн А/46 тоот тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй автомашин хүлээн авах комисс нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ХЭАХААГ/20250102002 тоот гэрээний дагуу нийлүүлэгч автомашинг гэрээний хавсралт, өрөмжийн болон тусгай нөхцөлд тусгагдсан шаварлагыг хангасан байдал, баруаны чанар, тээвэрлэлт, хадгалалтын байдал болон автомашины холбогдох баримтуудтай гэрээ дээр нь танилцан шалгав.
1.6 Гүйцэтгэгч нь автомашиныг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр гэрээнд заасны дагуу бүрэн нийлүүлж дууссан байна.

- ХОЕР ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ
2.1 Автомашиныг шалгаж үзээд, гүйцэтгэгч байгууллага гэрээний дагуу нийлүүлэгч автомашинг бүрэн нийлүүлж, гэрээгээр хүлээн үүрээ биелүүлсэн гэнэ дүгнэв.
2.2 Автомашиныг захиалагч байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлж, ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.
2.3 Автомашин хүлээн авах комиссын акт, холбогдох баримт бичиг, материалыг 4 эх хуви үйлдэж захиалагч, гүйцэтгэгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус бүрд нэг хувийг хургуулна.
2.4 Энэ актээр хүлээн авсан автомашины баримт бичгийн иж бүрдэл нь дараахивс бүрдэнэ. Үүнд:
а) Автомашины дарагдах техникийн бусад баримт бичиг;
б) Баталгаат засварын хугацаа холбогдох баримт;
в) Бусад

ГУРАВ АВТОМАШИНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Нэр төрөл	Марк	Үйлдвэрлэсэн улс, байгууллага, оноо	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Тээвэрлэлт үнэ /шаардлага автай бол бичнэ/	Усралт, туршилтын үнэ /шаардлага автай бол бичнэ/	Нийт үнэ
1	Toyota 4Runner	N280	Япон улс, 2016 он	1	176,500,000	0.0	0.0	176,500,000
2	Toyota prius	XW30	Япон улс, 2013 он	1	19,666,667	0.0	0.0	19,666,667
3	Toyota prius	XW30	Япон улс, 2013 он	1	19,666,667	0.0	0.0	19,666,667
4	Toyota prius	XW30	Япон улс, 2014 он	1	19,666,667	0.0	0.0	19,666,667
5	Toyota prius	XW30	Япон улс, 2014 он	1	19,666,667	0.0	0.0	19,666,667
6	Toyota prius	XW30	Япон улс, 2013 он	1	19,666,667	0.0	0.0	19,666,667

Зураг 1. Тендерт шалгарсан болон нийлүүлсэн автомашины харьцуулалт

3.2. Барилга байгууламжид захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн боловч фото зургаар баталгаажуулан тайлагнаагүй, архивын баримт үүсгээгүй байна.

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтын 56 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 9,730.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд 1 төсөл, арга хэмжээний гэрээний дүнг 49.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн шинэчлэн баталж бусад 55 төсөл, арга хэмжээний гэрээний дүн өөрчлөгдөөгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын дээвэр, ИШС-ний засварын граж төсөл, арга хэмжээний хүрээнд дээврийн пандус төмөр, сантехникийн узельд нэмэлт насос тавих, зарим өрөөний дотор засал хийх, тавилга авах зэрэг ажлыг нэмж гүйцэтгэн гэрээний дүнг 49.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

ОНХО-ын 7,507.8 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээнд аймгийн ГХБХБГ, 1,393.3 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ, 879.4 сая төгрөгийн 27

төсөл, арга хэмжээнд тухайн сумын ЗДТГ тус тус захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ГХБХБГ нь нийт 12 төсөл, арга хэмжээнд 28 удаа захиалагчийн хяналтыг, зураг төсөв зохиогч 16 төсөл, арга хэмжээнд 30 удаа зохиогчийн хяналт хэрэгжүүлж, ажлын тайланг фото зургаар баталгаажуулан архивын баримт бүрдүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар зураг төсөл, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг шууд хэрэгжүүлсэн бол сумын ИТХ-аас баталсан их засварын 273.4 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын 3,642.6 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт, 1,936.3 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээнд зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн гэх боловч фото зургаар баталгаажсан ажлын тайлан бүрдүүлж, архивын баримтад нэгтгээгүй байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн ГХБХБГ-т албан шаардлага/

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 51 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 2.2.2¹-т заасны дагуу 7,066.4 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч барилга, их засварыг ашиглалтад оруулах хүсэлт гаргасан бол 3,697.2 сая төгрөгийн 15 ажлыг гүйцэтгэгчийн хүсэлтгүйгээр ашиглалтад оруулах комисс ажилласан байна.

1. Гүйцэтгэгчээс барилга, угсралт, их засварын ажлыг ашиглалтад оруулах хүсэлт гаргаагүй байхад 3,602.1 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээнд улсын комисс ажилласан,

2. Нийлүүлэгчээс хүсэлт гаргаагүй зураг төсөл, тоног төхөөрөмжийн 373.9 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээнд хүлээн авах комисс ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн Засаг даргад Зөвлөмж/

Аймгийн ИТХ-аар батлагдсан хөрөнгө оруулалт, их засварын 18 ажилд аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын 20-ны №630 тоот тушаалаар баталсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллан хүлээн авсан бол Батширээт, Бор-Өндөр, Хэрлэн сумын ИТХ-аас баталсан 9 төсөл, арга хэмжээг сумын Засаг даргын Захирамжаар комисс томилон ашиглалтад оруулсан байна.

Үүнээс Засгийн газрын 2021 оны 212 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг зөрчин Хэрлэн сумын Засаг

¹ 2.2.2. энэ дүрмийн 2.2.1-т зааснаас бусад барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргад.

дарга ашиглалтад оруулах комиссыг томилон барилга байгууламж, их засварын 3 төсөл, арга хэмжээг хүлээн авсан байна.

Шийдвэрлэлт: /Хэрлэн сумын Засаг даргад албан шаардлага/

3.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг бүрэн бүртгэж, хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2025 онд ашиглалтад орсон 53 төсөл, арга хэмжээг 12,411.2 сая төгрөгийн хөрөнгийг төрийн өмчийн болон төсөвт байгууллагын удирдлагын шийдвэрээр санхүүгийн тайланд тусган, хөрөнгөнд бүртгэсэн байна.

Харин Бор-Өндөр сумын ИТХ-аас баталсан 91.1 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн бөгөөд 2026 онд шийдвэр гарган холбогдох байгууллагад бүртгэхээр шийдвэрлэсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт төсөл, арга хэмжээний 84.5% буюу 12,544.5 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 60 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэнээс 3,332.5 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ 2024 онд, 9,212.0 сая төгрөгийн 51 төсөл, арга хэмжээ 2025 онд дууссан байна.



Харин 7.0% буюу 568.5 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ гэрээний дагуу он дамжин хэрэгжиж байгаа бол 8.5% буюу 320.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдаагүй, хэрэгжээгүй байна.

Дүрслэл 5. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүнд 15 сургууль, цэцэрлэгийн 3755 хүүхдийн сурч, хүмүүжих болон дотуур байрны 372 сурагчийн амьдрах орчныг сайжруулж, давхардсан тоогоор 28000 гаруй ард иргэдэд соёлын үйлчилгээ хүргэж, эмнэлгийн тусламж үйлчилгээ болон тоног төхөөрөмжийн хангалтыг өмнөх оноос 9.1 хувиар нэмэгдүүлсэн байна.

Мөн 866 ахмад настанд сувиллын үйлчилгээг үзүүлж өмнөх оноос 8.6 хувиар өсгөн, “Өндөрхаан хот тохижилт” ОНӨААТҮГ-ын парк шинэчлэлтийг 52 хувьд хүргэж, Хэрлэн сумын 24.0 мянган иргэний амьдрах таатай орчныг бүрдүүлэх ажил хийгджээ.

Төрийн байгууллагын автопаркийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн, Хэрлэн, Жаргалтхаан сумын 1200 гаруй малчин өрх, 14000 гаруй иргэнд төрийн үйлчилгээг шуурхай хүргэж, гамшиг ослын үед иргэдийг байрлуулах түр байр болон сургалт дадлагын бэлтгэх хангах орчныг бүрдүүлжээ.

Орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт 2021-2025 оны аймгийн үндсэн чиглэлийн боловсруулахдаа арга хэмжээний суурь болон хүрэх түвшнийг тодорхойлж батлаагүйгээс хөрөнгө оруулалтын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнг үнэлэх боломжгүй байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын аудитын албан шаардлагаар өгсөн зураг төслийг бүрэн магадлуулах, Худалдан авах ажиллагаанд төлөвлөгөөнд заасан хугацаанд зохион байгуулах, ажлын тоо хэмжээнд заасан ажлыг бүрэн хийгддэггүй, зөвлөмжөөр өгсөн ХАА-ны хүний нөөцийг бүрдүүлэх, төлөвлөгөөнд заасан хугацаанд үнэлгээний хороог томилох, чанарын баталгаат хугацаанд гарсан гэмтлийг бүрэн засварлах зэрэг шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



Аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул аудитын тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Нийцлийн аудитаар нийт 6,492.7 сая төгрөгийн 10 зөрчил илрүүлснээс 1.696.5 сая төгрөгийн 7 албан шаардлагыг аймгийн Засаг дарга, Хэрлэн сумын Засаг дарга, Худалдан авах ажиллагааны газарт, зөрчил арилгах 493.2 сая төгрөгийн 3 зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд урсгал зардал, мөрийн хөтөлбөрийн зардлаас санхүүжих ажлыг тусгасан, магадлалаар баталгаажсан зураг төсөв, техникийн нөхцөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй төлөвлөсөн нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журамтай нийцэхгүй байна.
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацааг хэтрүүлсэн, техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцээгүй санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулсан байна.
- Төсвийн ерөнхийлөн Захирагчаас эрх шилжүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавиагүйгээс төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжээгүй байна.
- Төсөл, арга хэмжээг хүлээж авах комисс нь "Сумдын ЗДТГ-ын авто машин" төсөл, арга хэмжээний авто машиныг хүлээн авахдаа техникийн тодорхойлолтод нийцээгүй 176.5 сая төгрөгийн "4Runner" маркийн автомашиныг хүлээн авсан байна.
- Барилга, их засварын үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн хяналт хангалтгүйгээс ашиглалтад оруулах комисс бүх төсөл, арга хэмжээнүүдэд ажиллаагүй байна Барилга, их засварын ажлын үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.
- Хэрлэн сумын төсвөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг хүлээн авсан комисс нь Засгийн газрын тогтоолоор баталсан дүрмийн дагуу байгуулагдаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.АЮУРБУНЬ-Д

- Төсвийн ерөнхийлөн захирагч нь сумын ИТХ-аар батлагдаж байгаа хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 278 дугаар тогтоолд нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах
- Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд багтаан зохион байгуулж дуусгавар болгох, худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох
- Барилгын тухай хууль, тогтоомжийн дагуу ашиглалтад оруулах комиссыг томилж ажиллуулах

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ

Аудитын нэр: Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
Аудитын код: ХЭА-2026/05-22-ШТА-НА
Байгууллагын нэр: Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

№	Аудитын чиглэл, асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
Аудитын дэд зорилт А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ оновчтой төлөвлөсөн үү?						
А.1.2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, өртөг, санхүүжилт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлсон төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?						
1	А.1.2.3. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилж төлөвлөсөн үү?	Хот байгуулалт, барилга, орон сууцруулалтын сайдын Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах улсын төсвийн хөрөнгө багцад хамаарах Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилаагүй байна.	2,113,400,000.00	ҮАГ-Т САНАЛ: Хот байгуулалт, барилга, орон сууцруулалтын сайдын 2025 оны төсвийн XVIII.1.1 багцад батлагдсан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай уялдуулж тэнцүү хуваарилж төлөвлөхгүй байна.	<i>саналгүй</i>	
Дэд зорилт А.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?						
А.3.2. Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн үү?						
2	А.3.2.1. Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн үү?	Тайлант онд аймгийн ГХБХБГ нь "Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/, "Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/" төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан, фото зургаар баримтжуулаагүй байна.		АЛБАН ШААРДЛАГА 1: Барилга байгууламжийн үе шат бүрд хэрэгжүүлсэн зохиогчийн болон захиалагчийн хяналтын ажлыг тайлагнадаггүй, фото зургаар баримтжуулаагүй зөрчлийг таслан зогсоох	<i>саналгүй</i>	
3	А.3.2.5 Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлж байна уу?	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж төсөл, хэрэгжүүлэх талбайд байршуулах талаар Барилгын тухай хуульд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.		ЗӨВЛӨМЖ 1: Хуульд заасан захиалагчийн чиг үүргийн дагуу хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг MNS:7023:2023 стандартад заасны дагуу байршуулах	<i>саналгүй</i>	
Аудитын дэд зорилт Б.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн үү?						
Б.1.1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?						
4	Б.1.1.4. Сумын ИТХ-аас баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж, төлөвлөлтийн шаардлага хангаж байна уу?	1. Баянмөнх, Биндэр, Өмнөдэлгэр сумд орон нутгийн хөрөнгө оруулалтын 142.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар батлуулахгүйгээр хэрэгжүүлсэн. 2. Бор-Өндөр, Цэнхэрмандал сумд урсгалын шардлын шинжтэй 87.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөж сумын ИТХ-аар батлуулсан. 3. Бор-Өндөр сум Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс санхүүжих 18 төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад оруулж ИТХ-аар батлуулсан нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журамд заасан орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна.		ЗӨВЛӨМЖ 2: Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 278 дугаар тогтоолд нийцүүлэн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулах	<i>саналгүй</i>	
Б.1.2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, өртөг, санхүүжилт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлсон төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?						
5	Б.1.2.1. Магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлтэй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, техникийн нөхцөлгүй 324.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг 4 сумын ИТХ-аар, 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалт /Жаргалтхаан/ барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн нөхцөлгүй байхад аймгийн ИТХ-аар тус тус төлөвлөж батлуулсан байна.	977,623,600.00	АЛБАН ШААРДЛАГА 2: Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг төлөвлөдөг зөрчлийг таслан зогсоох	<i>саналгүй</i>	
6	Б.1.2.2. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тооцоололд үндэслэн ТЗҮУ, зураг төсөл, тоног төхөөрөмжийн өртгийг төлөвлөсөн үү?	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын даалгаваргүй 235.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ, техникийн тодорхойлолтгүй 206.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.	442,395,890.00	АЛБАН ШААРДЛАГА 3: Батлагдсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг төлөвлөдөг зөрчлийг таслан зогсоох	<i>саналгүй</i>	
Дэд зорилт Б.2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан үү?						
Б.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу, хугацаанд нь зохион байгуулсан үү?						
7	Б.2.1.4. Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулж дуусгасан үү?	Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн 493.2 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна. Үүнээс 300.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг тодотголоор нэмж баталсан боловч төсөв батлагдсан даруйд худалдан авах ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.	493,150,406.00	ЗӨВЛӨМЖ 3: Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд багтаан зохион байгуулж дуусгавар болгох, худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох	<i>саналгүй</i>	

8	Б.2.1.5. Төндөр шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангасан оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан уу?	1. "Сумын эрүүл мэндийн төвийн машин", "Сумдын Засаг даргын Тамгын газрын автомашин"-ы гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хорооны хуралд аймгийн Засаг даргын 2025 оны "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/201 дүгээр захирамжаар томилоогүй иргэний төлөөлөл оролцсон. 2. Үнэлгээний хороо нь 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй "Сумын эрүүл мэндийн төвийн машин" төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй санал ирүүлсэн гүйцэтгэгчийг шалгаруулсан байна. 3. Техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангахгүй санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулснаар зах зээлийн үнээс өндөр үнэтэй хөрөнгийг бэлтгэсэн байна.	100,000,000.00	АЛБАН ШААРДЛАГА 4: Техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
Дэд зорилт Б.3. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?						
Б.3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь санхүүжүүлж, гүйцэтгүүлсэн үү?						
9	Б.3.1.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлсэн үү?	Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан "Батширээт сумын ЗДТГ-ын байрны засвар" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Батширээт сумын Засаг даргад шилжүүлсэн боловч захирамжийн хэрэгжилт хангалтгүйгээс гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй байна.		АЛБАН ШААРДЛАГА 5: Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
10	Б.3.1.3. Төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн үү?	Аймгийн Засаг даргын 2025 оны А/46 дугаар захирамжаар томилсон ажлын хэсэг нь "Сумдын ЗДТГ-ын авто машин" төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авах ажиллагаанд ирүүлсэн техникийн тодорхойлолтод нийцээгүй, зөрүүтэй 176.5 сая төгрөгийн "Toyota 4Runner" маркийн автомашиныг хүлээн авсан байна.	176,500,000.00	АЛБАН ШААРДЛАГА 6: Худалдан авах ажиллагаанд шалгарсан техникийн тодорхойлолтоос зөрүүтэй тоног төхөөрөмж хүлээн авдаг зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
Б.3.2. Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн үү?						
11	Б.3.2.1 Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн үү?	Орон нутгийн хөрөнгө оруулалтын 3,608.8 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт, 1,857.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээнд зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн гэх боловч ажлын баримт бүрдүүлж, хадгаламжийн нэгжид оруулаагүй байна.		АЛБАН ШААРДЛАГА 1: Барилга байгууламжийн үе шат бүрд хэрэгжүүлсэн захиалагчийн хяналтын ажлын баримтыг бүрдүүлж, хадгаламжийн нэгжид оруулдаггүй зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
12	Б.3.2.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан уу?	1. Гүйцэтгэгчээс барилга, угсралт, их засварын ажлыг ашиглалтад оруулах хүсэлт гаргаагүй 3,602.1 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээнд улсыг комисс ажилласан. 2. Хөрөнгө оруулалтын 373.9 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс ажиллаагүй байна.		ЭӨВЛӨМЖ 4: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрд Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг бүрэн ажиллуулах	саналгүй	
13		Засгийн газрын 2021 оны 212 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг зөрчин Хэрлэн сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар нь ашиглалтад оруулах комиссыг томилон барилга байгууламж, их засварын 2 төсөл, арга хэмжээг хүлээн авсан байна.		АЛБАН ШААРДЛАГА 7: Засгийн газрын тогтоолоор баталсан дүрэмд нийцэхгүй комиссыг ажиллуулдаг зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
НИЙТ ДҮН			4,303,069,896.00			

Бэлтгэсэн:

Аудитор:

Ахлах аудитор:

Ахлах аудитор:

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер:

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор:

Т.Алтаншагай

Ц.Билэгсайхан

Д.Эрдэнэбилэг

Д.Оюунтуяа

Ж.Ганбаатар

Огноо

Огноо

Огноо

Огноо

Огноо

Танилцсан:

Хэнтий аймгийн Засаг дарга

Хэнтий аймгийн ЗДТГ-ын дарга

Хэнтий аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Худалдан авах ажиллагааны газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Хэрлэн сумын Засаг дарга биеийн Чингис хотын захирал

Д.Аюурбуны

А.Жаргалсайхан

Д.Баярхүү

Т.Батзорж

В.Сүмбээ

Д.Эрдэнэбаатар

Огноо

Огноо


Огноо

Огноо

Огноо

Огноо

Огноо



181910012
ИМТ1449-3* 76192

24070035 42600